

Эдийн засаг, хөгжлийн яамны
Төрийн нарийн бичгийн даргын 2026 оны
01 дугаар сарын 13-ний өдрийн 01 дугаар
тушаалын 12 дугаар хавсралт

АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ

А. ТАНИЛЦУУЛГА

1. Гэрээний дугаар:	2. Төсөл хэрэгжүүлэгч байгууллага: Эдийн засаг, хөгжлийн яам
3. Орон тоо, албан тушаал: Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн Мал аж ахуйн асуудал хариуцсан шинжээч	
4. Ажлын байрны шууд харьяалах удирдах албан тушаалын нэр: Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн Хөдөө аж ахуйн асуудал хариуцсан дэд зохицуулагч	

Б.ЧИГ ҮҮРЭГ

1. Ажлын байрны үндсэн зорилго:	Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн төслийн хүрээнд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, нүүрстөрөгч илүү шингээдэг, бага ялгаруулдаг бэлчээрийн тогтвортой менежментийг хэрэгжүүлж, бэлчээрийн доройтлыг бууруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх; Өвс, тэжээлийн таримал тариалах системийг төлөвлөх, хэрэгжүүлэх, мөн тэжээлийн үйлдвэрлэлийг дэмжих услалтын системийг бий болгох, засвар үйлчилгээ хийх, төслийн болон хөрөнгө оруулалтын хөтөлбөрт заасан тариалангийн үйлдвэрлэлийн хэрэгжилтийн явцыг хянах, төслийн багт дэмжлэг үзүүлэхэд оршино.	
2. Ажлын байрны дэд зорилтууд:	1. Төслийг Монгол Улсын Засгийн газар болон Хөгжлийн түншүүдийн бодлого, удирдамж, зааварт нийцүүлэн хэрэгжүүлэх; 2. Бэлчээр хамгаалал, нөхөн сэргээлт, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон нүүрстөрөгчийн хуримтлал ихтэй бэлчээрийн менежментийг хэрэгжүүлэх.	
3. Ажлын байрны үндсэн үйл ажиллагаа:	Хугацаа/ хуваарь	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт
1. Төслийн зөвлөхүүд, төрийн болон орон нутгийн байгууллагууд, төслийн удирдах хороо, Хөгжлийн түншүүдийн бусад хандивлагч, оролцогч талуудыг өөрийн хариуцсан ажлын хүрээнд мэдээллээр хангана; 2. СЯ, ЭЗХЯ, ХХААХҮЯ, Хөгжлийн түншүүдийн шаардлагад нийцсэн тайлан, мэдээллийг цаг тухайд нь бэлтгэж удирдлагыг мэдээллээр хангана; 3. Мэдлэг хуваалцахыг дэмжих зорилгоор олон нийтийн хурал, зөвлөгөөн,	Төсөл хэрэгжих хугацаанд	Үйл ажиллагааны явцын тайлан, сар, улирал, жилийн тайлан

сургалтуудыг зохион байгуулах, хамрагдах; 4. Ногоон ХАА-нутаг дэвсгэрийн нэгдмэл хөгжил болон уур амьсгалын өөрчлөлтөд ухаалгаар дасан зохицсон МАА, бэлчээрийн менежментэд зохих бодлого, төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, мөрдүүлэх төрийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх үүднээс хөтөлбөрийн бодлогын хүрээг хэрэгжүүлнэ; 5. Төслийн мэдлэгийн санд хувь нэмрээ оруулахын тулд төслийн үйл ажиллагааны талаар тогтмол тайлан гаргаж, сурсан сургамжийг баримтжуулах. 6. Бэлчээр ашиглах гэрээ, бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулахад төрийн болон ТББ, бусад оролцогч талуудын уялдааг хангаж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавина; 7. Бэлчээр ашиглах хэсгүүд шинээр байгуулах, байгуулагдсан бэлчээр ашиглагчдын хэсгүүдийг чадавхжуулах, хөгжүүлэхэд нь зөвлөн туслах ажлыг хэрэгжүүлнэ; 8. Бэлчээрийг нөхөн сэргээх, зохистой ашиглах чиглэлээр орон нутагт тохирсон үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахад дэмжлэг үзүүлнэ; 9. Бэлчээрийн доройтлыг багасгаж, малын ашиг шимийг дээшлүүлэхийн тулд бэлчээр ашиглалтын зөв дадал хэвшүүлэх, бэлчээр хамгаалах арга техникийг сургах ажлыг зохион байгуулна; 10. Бэлчээрийн төлөв байдал, өөрчлөлтийг фото мониторинг, зайнаас тандан судлах зэрэг дэвшилтэт технологийн аргаар үнэлэх, судлах чадавхыг хөгжүүлнэ; 11. Нүүрстөрөгчийн ялгарал багатай бэлчээрийн менежментийг нэвтрүүлэх зорилгоор, СО₂-ын шингээлтийн чиглэлээр сургалт, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, оролцох; 12. Улсын хэмжээнд болон гадаад улсуудад давтан хэрэгжүүлэх боломжтой ногоон ХАА-нутаг дэвсгэрийн хөгжлийн загварыг бий болгох, нүүрстөрөгч багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон		
--	--	--

бэлчээрийн менежментийн түншлэл байгуулах боломжийг судална; 13. Бэлчээрийн менежментийн үйл ажиллагааны үр нөлөөг үнэлэх зорилгоор бэлчээрийн газрын хяналтын системийг бий болгож ашиглах, мэдээлэлд тулгуурласан шийдвэр гаргах боломжийг бий болгоно; 14. Бэлчээрийн даацад нийцүүлэн малын тоо толгойг бууруулах чиглэлийн арга хэмжээ зохион байгуулж, арга зүйгээр хангана; 15. Бэлчээрийн доройтлыг бууруулах үйл ажиллагаанд идэвх санаачилга гаргасан үр дүнг тооцож түүнд тохирсон урамшуулал олгох аргачлалыг боловсруулах ажлыг зохион байгуулна; 16. Хиймэл дагуулаас мэдээлэл авах дата хүлээн авагч бүхий зайнаас тандан судлах лаборатори болон хөрсний шинжилгээний итгэмжлэгдсэн лаборатори (судалгаа ба хөгжүүлэлтийн төв) байгуулах ажлын ажлын даалгаварт бэлчээрт холбогдолтой санал оруулах, ашиглалтын гарын авлага журам боловсруулах ажлыг зохион байгуулна; 17. Бэлчээрийн усан хангамж, худаг уст цэг шинээр гаргах, сэргээж сайжруулахтай холбоотой ажлыг хариуцан зохион байгуулна; 18. Олон нийтэд суурилсан хөрөнгө оруулалтын төслийг Мал аж ахуй агро-бизнесийн мэргэжилтэн, Малчдын байгууллага, баталгаажуулалтын мэргэжилтэнтэй хамтран боловсруулах, хэрэгжүүлэх. 19. Тэжээлийн таримлын төрөл, үр сортыг тохиромжтой дулааны хангамжтай нь уялдуулан сонгох 20. Тариалангийн технологийг мөрдөх, хөрсний үржил шим сайжруулах, ургамал хамгааллын зохистой дадал нэвтрүүлэх үйл ажиллагаанд зөвлөгөө өгч, сургалт зохион байгуулах. 21. Газар тариалангийн үйлдвэрлэлд оператор, жолооч, механикжуулагчдыг Хөдөө аж ахуйн машин, агрегатыг жолоодох, усалгааны машин ажиллуулах, засвар үйлчилгээ хийхэд сургалт зохион байгуулах. 22. Тэжээлийн үйлдвэрлэлийн хэрэгцээнд тохирсон үр ашигтай усалгааны		
--	--	--

системийг сонгох, суурилуулах инженерүүдтэй хамтран ажиллах. 23. Услалтын системийн барилга байгууламжийн өмчлөл, эзэмших, ашиглахтай холбогдолтой асуудлуудын эрх зүй бодлого шийдвэрт нийцэж байгаа эсэхэд холбогдох байгууллага, удирдлагуудтай хэлэлцүүлэг, санал солилцож, шийдэлд хүрэх асуудал боловсруулах. 24. Услалтын системийн засвар үйлчилгээ, усны ашиглалтын үр ашиг, тогтвортой байдлыг хангахад хяналт тавих. 25. Тариаланчдыг усалгааны системийн ашиглалт, засвар үйлчилгээний талаар сургаж, ус хэмнэх арга техникийг зөвлөх, эрх зүйн зөвлөмж өгөх 26. Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө гарын авлага, зөвлөмж боловсруулах, мэдлэг олгох.		
Тайлбар: Ажил гүйцэтгэх хугацаа, хуваарийг жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр тодорхойлно.		

В. АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

1.Ажлын байранд тавигдах шаардлага	1.1.Ерөнхий шаардлага	Үзүүлэлт	Чухал шаардлагатай	Шаардлагатай
		Боловсрол	Магистр болон түүнээс дээш зэрэгтэй байх	Зөвлөх зэрэгтэй бол давуу тал болно.
		Мэргэжил	Хөдөө аж ахуйн шинжлэх ухаан /0811/, эсвэл холбогдох чиглэлээр бакалавр	
		Туршлага	хөдөө аж ахуйн салбарт бодлого боловсруулах, үйл ажиллагааны чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай; харилцааны болон хүмүүстэй харилцах чадвар сайтай байх; асуудал шийдвэрлэх ур чадвар, хөдөө орон нутгийн орчинд ажиллах дасан зохицох чадвар; газар тариалан, хөдөө аж ахуйн төсөл, санаачилгын үр дүнтэй хэрэгжилтийг	Хөдөө аж ахуйн салбарт тэр дундаа газар тариалан, агрономын чиглэлээр ажилласан байх.

			хангахын тулд төслийн талбайд ажиллахад тууштай байх;	
		Ур чадвар	Англи хэлний аман болон бичгийн харилцааны өндөр ур чадвартай байх	
	1.2.Тусгай шаардлага	-	Орон нутагт томилолтоор ажиллах боломжтой байх.	

Г. АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТЫГ БАТАЛСАН:

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ	
Шийдвэрийн огноо:	2026.01.13
Дугаар:	A/04
(тамга/ тэмдэг)	
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА	(И.БАТХҮҮ)
2026 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр	

